

**БУЛГАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2026 ОНЫ 4 САР**

2026-05-08

Булган

2026 оны 4 сарын байдлаар нийт орлого ба тусламжийн дүн **25,7** тэрбум төгрөг буюу 99,0 хувийн, нийт зарлага **25,9** тэрбум төгрөг буюу 88,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

1. Төсвийн орлого

Нийт орлого ба тусламжийн дүн **25,7** тэрбум төгрөг буюу **99.0** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 2,8 тэрбум төгрөг буюу 9,8 хувиар буурч, урсгал орлого 2,1 тэрбум төгрөгөөр буюу 10,0 хувиар өссөн байна. Тайлант оны урсгал орлогын гүйцэтгэл **22,8** тэрбум төгрөг буюу **102,8** хувь байна.

(сая төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл (өссөн дүнгээр)	хэмнэлт/хэтрэлт (Тайлант үеийн)		хэмнэлт/хэтрэлт (ӨО-ны мөн үетэй харьцуулсан)	
		жилээр	тайлант үе (өссөн дүнгээр)		зөрүү	Хувь, %	зөрүү	Хувь, %
1	2	3	4	5	(4-5)	(5:4)	(5-2)	(5:2)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	28,457.9	86,175.2	25,937.9	25,682.7	255.2	99.0	(2,775.2)	90.2
Урсгал орлого	20,712.1	72,794.2	22,163.9	22,783.9	(620.0)	102.8	2,071.8	110.0
Татварын орлого	19,175.6	61,844.8	20,514.1	21,215.9	(0.7)	103.4	2,040.3	110.6
Татварын бус орлого	1,536.5	10,839.4	1,649.7	1,562.9	0.1	94.7	26.5	101.7
Хөрөнгийн орлого	62.4	110.0	-	5.0	(0.0)	-	(57.4)	8.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын	7,683.5	13,380.9	3,774.0	2,898.8	875.2	76.8	(4,784.6)	37.7
ОНХНСангаас шилжүүлсэн орлого	1,718.4	10,666.9	2,869.3	1,994.1	875.2	-	275.8	0.0
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	5,965.1	2,714.0	904.7	904.7	-	-	(5,060.4)	15.2

Нийт орлогын 11,3 хувийг тусламж санхүүжилтийн орлого, 82,6 хувийг татварын орлого, 6,1 хувийг татварын бус орлого эзэлж байна. Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 12,1 тэрбум төгрөг буюу татварын орлогын 57,2 хувийг бүрдүүллээ. Аймгийн дүнгээр авч үзвэл авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөр, хөрөнгө борлуулсны орлого биелж бусад орлогын биелэлт 46,2%-96,2% байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2,0 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлэг авч сумдад 0,7 тэрбум төгрөгийг олгосон.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Булган аймагт хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гадаад зээлийн эргэн төлөлтийг орон нутгийн өмчит Булган мээж ХХК, Тэшиг ус ХХК-иуд эргэн төлөх чадваргүй байгаагаас зээлийн хүүгийн орлого тасарч байна.

Сумдын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **12,2** тэрбум төгрөг буюу **100,5** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: татварын орлогыг сумаар авч үзвэл:

(сая төг)

д/д	Сумын нэр	2026 он төлөв.	2026 он 4 сар төлөв.	2026 он 4 сар гүйц.	зөрүү	хувь, %
1	Баян-Агт	748.4	199.8	208.9	-9.1	104.6
2	Баяннуур	569.7	187	161.1	25.9	86.1
3	Бугат	626.5	147.7	161.7	-14	109.5
4	Булган	12333.2	3693.7	3329.7	364	90.1
5	Бүрэгхангай	1918.4	648.7	524.3	124.4	80.8

6	Гурванбулаг	943.1	255	337.6	-82.6	132.4
7	Дашинчилэн	729.5	204.8	252.3	-47.5	123.2
8	Могод	600.8	153	185.9	-32.9	121.5
9	Орхон	1720.7	479.2	456.7	22.5	95.3
10	Рашаант	1653.5	568.2	457.3	110.9	80.5
11	Сайхан	710.6	182.1	194.8	-12.7	107.0
12	Сэлэнгэ	1011.6	268.3	333.3	-65	124.2
13	Тэшиг	1558.1	426.8	646.6	-219.8	151.5
14	Хангал	5024.6	1578.9	1635.7	-56.8	103.6
15	Хишиг-Сндөр	816.4	243.3	234.8	8.5	96.5
16	Хутаг-Сндөр	1755.5	475.4	488.6	-13.2	102.8
17	Хялганат	1468.6	485.5	374.6	110.9	77.2
	СУМЫН ДҮН	34,189.2	10,197.4	9,983.9	213.5	97.9
18	Аймгийн орлого	32,045.5	11,383.6	11,950.8	-567.2	105.0
	НИЙТ ОРЛОГО	66,234.7	21,581.0	21,934.7	-353.7	101.6

Баян-Агт, Бугат, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сумын татварын орлогын төлөвлөгөө биелсэн байна.

2. Төсвийн зарлага

Аймгийн төсвийн нийт зарлага **25,9** тэрбум төгрөг буюу **88,0** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **20,3** тэрбум төгрөг буюу **86,8** хувь, орон нутаг дахь улсын төсвийн байгууллагын тогтмол зардал **5,7** тэрбум төгрөг буюу **92,4** хувь байна. Орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 8,2 тэрбум төгрөг буюу нийт зардлын 31.5%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,9 тэрбум төгрөг буюу нийт зардлын 34,0%, хөрөнгийн зардал 2,5 тэрбум төгрөг буюу нийт зардлын 9,5 хувийг эзэлж байна. Энэхүү 3 бүлгийн зардал нийт зардлын 75,0%-ийг эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын гүйлгээний эрх хязгаарлагдсан, эрх тавигдсан хэмжээгээр гүйлгээ хийгдэж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 267,1 сая, аймгийн ОНХСангийн гүйцэтгэл 637,9 сая, Байгаль хамгаалах сангийн гүйцэтгэл 1,295.9 сая төгрөг байна.

3. Төсвийн өглөг, авлага

Улсын төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан Сангийн яамнаас 1-4 сард цалин, ажил олгогчоос төлөх НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, шатахуун, шуудан холбооны зардлын эрхийг нээж бусад зардлын зарцуулалтын эрхийг хязгаарласнаас шалтгаалан орон нутгийн төсөвт байгууллагууд нийт 233,2 сая төгрөгийн өр шинээр үүссэн байна. Үүнээс тогтмол зардлын өр 187,1 сая төгрөг байна. ЕБС-ийн дотуур байрны халаалтыг м3-ээр хэмжиж тооцох болсноос шалтгаалан халаалтын өр үүссэн байна.

2025 оны жилийн эцсээр 3,530.4 сая төгрөгийн өртэй гарсан. Үүнээс хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 3,100.4 сая буюу нийт өрийн 87,8%-ийг эзэлж байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС